



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/350

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Ховд аймгаас Дорнод аймаг хүртэл 2127 километр хэт холын зайн гүйлтээ амжилттай гүйцэтгэсэн Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжимчин, цэрэгжилтийн спортын мастер, Ахлах ахлагч Э.Даваажамцыг угтан авах ёслолын ажиллагааны зардалд 2 549 400 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 2 549 400 төгрөг /Хоёр сая таван зуун дөчин есөн мянга дөрвөн зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
07 дугаар сарын 21-ний өдрийн
А/350 дугаар захирамжийн хавсралт

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 123 ДУГААР АНГИЙН ХӨГЖИМЧИН, ЦЭРЭГЖИЛТИЙН
СПОРТЫН МАСТЕР, АХЛАХ АХЛАГЧ Э.ДАВААЖАМЦЫГ
УГТАН АВАХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

Д.д	Засвар үйлчилгээний зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1.	Хулдаасан хэвлэл /2.40*7.5/	ш	1	270 000	270.0
2.	Том туг хийх атлас материал	ш	13	5 000	65.0
3.	Хийн бөмбөлөг	уут	10	7 000	70.0
4.	Цэцэг	ш	40	10 000	400.0
5.	Жижиг дарцаг	ш	200	5 000	1 000.0
6.	Жижиг дарцагны иш	ш	200	200	40.0
7.	Том дарцагны иш	ш	1	194 400	194.4
8.	Сүү, ааруул	кг	1	20 000	20.0
9.	Хадаг	ш	2	2 500	5.0
10.	Бэлэгний цэцэг	ш	3	30 000	90.0
11.	Чимэглэлийн тууз	ш	22	4 000	88.0
12.	Цэцэгний хөл	ш	2	35 000	70.0
13.	Цэцэгний тууз	ш	2	25 000	50.0
14.	Гарын бэлэг /хүүхдэд/	ш	3	25 000	75.0
15.	Оёдлын утас	ш	4	3 000	12.0
16.	Бусад зардал /олс, скоч, цэцэгний чимэглэл гэх мэт/	ш	1	100 000	100.0
ДҮН					2549.4